



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ СУРГУУЛЬ



**ОЛОН УЛСЫН
ХАРИЛЦАА**
(ТУСТАЙ ДУГААР)

WORLD AFFAIRS
(SPECIAL ISSUE)

2011 №2 364 (23)



УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ СУРГУУЛЬ



**ОЛОН УЛСЫН
ХАРИЛЦАА**
(ТУСГАЙ ДУГААР)

WORLD AFFAIRS
(SPECIAL ISSUE)

2011 №2 364 (23)



Улаанбаатар хот

DDC
327.015
O-295

Тус сэтгүүл нь анх 1996 оноос “Алтан аргамж” нэрээр, 2002 оноос “Олон улсын харилцаа” нэрээр гарч байна.

The journal has been published since 1996 as “Altan argamj” and since 2002 as “World Affairs”

Сэтгүүлийн зөвлөл:

Эрхлэгч:

Н.Алтанцэцэг (Проф., Ph.D)

Нарийн бичгийн дарга:

Д.Тунгалаг (Проф., Ph.D)

Гишүүд:

Ж.Баясах (Проф., Sc.D)
Д.Отгончимэг (Проф., Ph.D)
Б.Энхбаяр (Проф., Ph.D)
Д.Цолмон (Проф., Ph.D)
Д.Намсрай (Проф., Ph.D)
Ж.Баттогтох (Дэд проф., Ph.D)

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

С.Оюунсүрэн (Ph.D)

Сэтгүүлийн хаяг:

МУИС-ийн Олон улсын харилцааны сургууль
Шуудангийн салбар - 46 а, хайрцаг - 6
Улаанбаатар, Монгол улс
Утас: 354610;354611;354618
Факс: (976-11) 354610
E-mail: muis_sfs@yahoo.com

Editorial Board:

Editor in Chief:

N.Altantsetseg (Prof., Ph.D)

Assistant Editor

D. Tungalag (Prof., Ph.D)

Members:

J.Bayasakh (Prof.,Sc.D)
D.Otgonchimeg (Prof., Ph.D)
B.Enkhbayar (Prof., Ph.D)
D.Tsolmon (Prof., Ph.D)
D.Namsrai (Prof., Ph.D)
J.Battogtokh (Prof., Ph.D)

Publishing design:

S.Oyunsuren (Ph.D)

Editorial Address:

School of Foreign Service
National University of Mongolia
P.O.-46 a, Box-6
Ulaanbaatar, Mongolia
Tel:354610; 354611;354618
Fax: (976-11) 354610
E-mail: muis_sfs@yahoo.com

ISBN 978 99962 53 62 1

ГАРЧИГ

I. Монгол улсын гадаад бодлого, олон улсын харилцаа, түүх

Даяаршлын үеийн Энэтхэгийн гадаад бодлогын онцлог, шинэчлэл ба Монгол улсын байр суурь	5
<i>Н.Алтанцэцэг</i>	
Тайваньд өнгөрүүлсэн бүтэн сар хагас	12
<i>Ж. Баясах</i>	
Хубилай хааны түүхэнд гүйцэтгэсэн үүрэг	17
<i>Ж. Баясах</i>	
Монгол, Японы дипломат харилцааны хөгжлийн үечлэл	24
<i>Н.Бадрал</i>	
Японы соёлын дипломат ажиллагааны түүхэн тойм, өнөөгийн чиг хандлага	29
<i>Д.Оюунцэцэг</i>	

II. Олон улсын эрх зүй

Хил дамнасан гэмт хэрэг ба Монгол улсын үндэсний аюулгүй байдал	43
<i>А.Батсайхан</i>	
Гэрч, хохирогчийг хамгаалах талаар олон улсын эрх зүйн стандарт	56
<i>М. Мөнхбат</i>	
Олон улсын арбитрын хөгжлийн чиг хандлага	64
<i>Б. Улаанбаатар</i>	

III. Олон улсын эдийн засгийн харилцаа

Уул уурхайн нөлөөллийн бүсэд хийсэн судалгааны үр дүн	75
<i>Д. Намсрай, Д.Отгончимэг</i>	
Хятадын өнөө ба ирээдүй	80
<i>Х.Эрдэнэчулуун, Ю. Отгонжаргал</i>	
Монгол улс дахь БНХАУ-ын хөрөнгө оруулалт	87
<i>Н.Төмөр</i>	
Валютын дайн	97
<i>Д.Тунгалаг</i>	
Бэлэн мөнгөтэй биеэ даасан сангууд	102
<i>Б.Санжмятав</i>	

ДАЯАРШЛЫН ҮЕИЙН ЭНЭТХЭГИЙН ГАДААД БОДЛОГЫН ОНЦЛОГ, ШИНЭЧЛЭЛ БА МОНГОЛ УЛСЫН БАЙР СУУРЬ

Н.Алтанцэцэг¹

Энэтхэг улс шинэ зууны босгон дээр бүс нутагтаа төдийгүй дэлхийд хүчирхэгжин хөгжиж байгаа Азийн том гүрэн болоод байна. Хүн амын тоогоор дэлхийд тэргүүлж байгаа Хятад улс өнөөгийн байдлаар 1,3 тэрбум хүн амтай бол Энэтхэг удаалан 1,08 тэрбум хүн амтай. 2040 он гэхэд Энэтхэгийн хүн ам 1,5 тэрбумд хүрэхэд Хятадын хүн ам 1,45 тэрбумд болж Энэтхэг хүн амын тоогоор тэргүүлэх урьдчилсан тооцоо гараад байна.

Хүн амын тоогоор тэргүүлэх хоёр том гүрний эдийн засгийн өсөлт дэлхий нийтийн анхаарлын төвд байна. Хятад улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 2004 оноос дунджаар 9,1 хувийн өсөлттэй байгаа бол Энэтхэг улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 2004 оноос дунджаар 6,2 хувьтай өсч байгаа бөгөөд аль аль нь дэлхийн эдийн засгийн хямралд автагдахааргүй бодлого баримталж байгаагаараа онцлог юм. Энэ хоёр улсын эдийн засгийн өсөлтийг дагаад дэлхийн хүчний харьцаа “өрнөөс дорно руу” чиглэж байгаа талаар дэлхийн улс төрчид, судлаачид хэдийнээ анхааран судалж өөр өөрсдийн үнэлэлт дүгнэлтүүдийг өгсөөр байна. Энэтхэг улс эдийн засгийн хөгжлөөрөө 30-40 жилийн хугацаанд дэлхийн тэргүүлэгч гүрэн болно хэмээн үзэж байна.²

Энэ удаагийн илтгэлдээ би Энэтхэгийн гадаад бодлогын онцлог, өөрчлөлтийг тоймлон авч үзээд энэ нөхцөл байдалд Монголын гадаад бодлого Энэтхэгийн гадаад бодлоготой хэрхэн уялдан зохицох, аль салбарт илүү түлхүү хамтарч ажиллах тал дээр өөрийн санал бодлоо та бүхний сонорт толилуулъя гэжбодсон юм.

Монгол орон “гуравдахь хөрш” буюу “гуравдахь түнш”-ийн бодлого баримталж байгаа өнөөгийн нөхцөлд бүс нутаг болон олон талт хамтын ажиллагаанд өөрийн байр суурийг улам бүр бэхжүүлэх болсон Энэтхэгийн гадаад бодлого, түүний хувьсал хөгжилд анхаарлаа хандуулж, хамтын ажиллагааг түлхүү хөгжүүлэхэд анхаарах цаг болсон гэж би судлаачийн хувьд үздэг байсан. Гэтэл саяхан арваадхан хоногийн өмнө өөрөөр хэлбэл 2011 оны 7 дугаар сарын 29-өөс 8 дугаар сарын 1-нд Энэтхэгийн Ерөнхийлөгч Пратибха Девисинкх Патил Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар Монгол улсад зуу шахам төлөөлөгчийн хамт албан ёсны айлчлал хийсэн явдал Монгол-Энэтхэгийн харилцааг бүх шатанд гүнзгийрүүлэн хөгжүүлэх явдал хоёр орны ашиг сонирхолд бүрэн нийцэж байгааг харуулсан түүхэн үйл явдал боллоо.

Энэтхэгийн гадаад бодлого өөрийн гэсэн бие даасан байдалтай хөгжиж ирсэн бөгөөд дэлхийн хүчний тэнцвэрт гарсан өөрчлөлтийн хүрээнд өөрөөр хэлбэл хүйтэн дайн дуусгавар

¹ МУИС-ийн ОУХС-ийн захирал, доктор (Ph.D)

² 40 жилийн дараа эдийн засгаараа тэргүүлнэ. Өдрийн шуудан сонин. 2011.07.29

болсон үеэс түүний гадаад бодлогод ч өөрчлөлт орж, цаашид өргөжин гүнзгийрэх үндэс суурь нь тавигдаад байна. Энэтхэгийн гадаад бодлогын онцлог, түүнд гарч буй өөрчлөлтийг тоймлон дүгнэвэл:

Нэгдүгээрт: Энэтхэг улс тусгаар тогтнолоо зарлан тунхагласан үеэс өөрийн гадаад бодлогын бие даасан чиглэл болох “эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн” /Non-Alignment Movement/-ийг удирдан зохион байгуулж, Ази, Африкийн орнуудыг нэгтгэж колончлол, зэвсэглэлээр хөөцөлдөх, жанжлалын эсрэг тэмцэх бодлогыг баримталж, өргөн дипломат ажиллагаа явуулж байсан. Хүйтэн дайны үед Энэтхэгийн “ЭҮНХ”-ийг хоёр туйлд хуваагдсан ертөнц эсэргүүцэх, үгүйсгэх, басамжлах хандлагатай байсан бол өнөөгийн олон улсын харилцааны шинэ нөхцөл байдалд Ази, Африкийн орнууд бие даасан гадаад бодлого явуулах бололцоотой болсноор нэг талаас, нөгөө талаас дэлхийд жанжлах бодлого нэг туйлаас олон туйлд шилжих нөхцөл байдал бий болох болсноор “Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний”-ийг дэмжих, түүний үйл хэрэгт өргөнөөр оролцох сонирхолтой болоод байна. ЭҮНХ-ний зорилго, зорилт ч өөрчлөгдөж улс төрийн гэхээсээ илүү хөгжиж буй орнуудын өмнө тулгарч буй нийтлэг эрх ашиг болох эдийн засаг, хөгжил, байгаль, экологийн асуудлыг хөндөж тавьдаг болоод байна. Үүний нэг жишээ бол Монгол улс анх 1986 онд Гадаад хэргийн сайдын түвшинд ЭҮНХ-ний 8 дахь чуулга уулзалтанд оролцож байсан бол 1991 онд ЭҮНХ-ний 103 дахь албан ёсны гишүүн орон болсон байна. Өнөөдөр ЭҮНХ дэлхийн 118 орныг хамарсан энх тайван, хөгжил дэвшил, ардчиллын төлөөх томоохон хөдөлгөөн болоод байна. Энэтхэг орон ч энэ хөдөлгөөнд чухал, тэргүүлэх байр суурьтай байсаар байна.

Орчин үед Энэтхэгийн улс төр судлаачид, гадаад бодлогын шийдвэр гаргагчид, судлаачдын дунд ЭҮНХ-ийг үргэлжлүүлэн идэвхтэй үйл ажиллагаа явуулахыг дэмжсээр байна. Мөн энэ бодлогыг цаг үеэ өнгөрөөсөн олон улсын шинэ чиг хандлагад нийцэхээ больсон гэж үзэгчид ч байсаар байна.

Монгол улсын хувьд энэ хөдөлгөөнд идэвхтэй оролцсоноор өөрийн цөмийн зэвсэггүй статусыг дэмжүүлж чадсан. Мөн уул уурхайн салбарт байгалийн баялгаа хөгжингүй орнуудад “цөлмүүлж” байгаа Ази, Африкийн олон орны нэгэн адил энэ хөдөлгөөнийг ашиглаж дуу хоолойгоо нэгтгэн тэмцэх бүрэн боломжтой гэж үзэж байна. Нөгөөтэйгүүр Монгол улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгааг дэмжүүлэх, эдийн засаг, нийгмийн хөгжил, ардчилал, хүний эрх чөлөөг хамгаалах, түүний төлөө дуу хоолойгоо нэгтгэн тэмцэх боломж олгох нэг том олон улсын хүчин зүйл нь Энэтхэгийн гадаад бодлогын уламжлалт болон шинэчлэгдэн өөрчлөгдөж байгаа ЭҮНХ юм. Монгол улс энэ хөдөлгөөнд улам бүр идэвхтэй оролцож, өөрийн байр сууриа илэрхийлж, хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох ёстой гэж үзэж байна.

Хоёрдугаарт: Энэтхэг улс цөмийн зэвсгийн туршилт хийж /1967, 1974, 1998/, өөрийгөө цөмийн зэвсэгтэй гүрэн болохоо дэлхий нийтэд харуулснаар цөмийн зэвсэгтэй их гүрнүүд Энэтхэгтэй “эн тэгш” харилцах болсон. Өөрөөр хэлбэл Энэтхэгийн олон улсын тавцанд эзлэх байр суурь, нэр хүнд өсөн нэмэгдэж, их гүрнүүд болон Энэтхэгийн харилцаанд зарчмын өөрчлөлтүүд гарч ирсэн. Хэдийгээр цөмийн зэвсэгтэй их гүрнүүдийн цөмийн зэвсгийн талаар баримтлах бодлого Монгол улсад төдийлэн хамаагүй мэт боловч цөмийн зэвсэгтэй хоёр их гүрнээр хүрээлүүлсэн, цөмийн зэвсэггүй статусаа зарласан, түүнийгээ олон улсын эрх зүйгээр юуны түрүүнд хөрш хоёр орноор хуульчлан баталгаажуулах алхам хийж байгаа Монгол орны хувьд цөмийн зэвсэгтэй гүрнүүдийн цөмийн зэвсгийн болон цөмийн хөтөлбөрийн бодлогод хэрхэн хандаж, харилцаж

байгааг анхааран судалж өөрийн орны цөмийн зэвсэггүй статусаа баталгаажуулах гарц хайх, дэмжүүлэх алхам хайх тал дээр санал бодлоо хуваалцах нь зүйтэй мэт санагдана.

Энэтхэг улс **Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээ болон Цөмийн туршилтыг иж бүрэн хориглох гэрээнд** нэгдэн ороогүй байгаа нь цөмийн зэвсэгтэй гүрнүүд болон олон улсын анхаарлыг ихээр татаж байгаа юм. Гэтэл Энэтхэг нь “албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн цөмийн зэвсэгтэй орнууд ЦЗҮДГ, ЦТИБХГ болон бусад гэрээнүүдээр түрүү барин ноёрхож, тэдгээрт Энэтхэг улсыг нэгдэхийг шаардаж, өөрсдийн цөмийн бодлогоор монополь тогтоохыг зорьж байна”³ гэж үзэж байна. Мөн Энэтхэг улс өөрийг нь бүсэлсэн цөмийн цөмийн зэвсэгтэй Хятад, Пакистаны цөмийн зэвсгээр хөөцөлдөж буй бодлогын эсрэг авч байгаа арга хэмжээ гэж үзэж байна. Гэсэн хэдий ч Энэтхэгийн Ерөнхий сайд Атал Бехари Важпай цөмийн зэвсгийн бодлогын талаарх засгийн газрын албан ёсны байр сууриа илэрхийлэхдээ “Цөмийн зэвсгийг хамгийн бага хэмжээнд барих бөгөөд найдвартай хориглолт хийх, өөрийн цөмийн зэвсгийг цөмийн зэвсэггүй улсуудын эсрэг хэрэглэхгүй, мөн цөмийн зэвсэгтэй улсуудын эсрэг цөмийн зэвсгээ түрүүлж хэрэглэхгүй, зэвсэглэлийг үл ялгалгүйгээр хяналт тавих, зэвсэглэлийг хураах арга хэмжээ зохион байгуулахаа”⁴ мэдэгдсэн байна. Ерөнхий сайд А.Б.Важпайн мэдэгсэн “Бид цөмийн зэвсгийг түрүүлж хэрэглэхгүй. Цохон тэмдэглэхэд цөмийн зэвсэггүй улсуудын эсрэг цөмийн зэвсэг хэрэглэх ямар ч үндэс байхгүй” гэсэн нь Монгол шиг цөмийн зэвсэггүй орны цөмийн зэвсгийн халдлагын эсрэг аюулгүй байдлаа хамгаалах явдлаа баталгаажуулах гэсэн байр суурьтай бүрэн нийцэж байна.

Энэтхэгийн “цөмийн зэвсгийг цөмийн зэвсэггүй улсуудын эсрэг хэрэглэхгүй байх” зарчмыг бусад цөмийн зэвсэгтэй гүрнүүд, ялангуяа манай өмнөд, хойд хоёр хөршөөр хүлээн зөвшөөрүүлэх тал дээр Монгол улс хамтарч ажиллах нь зүйтэй гэсэн санал дэвшүүлж байна.

Гуравдугаарт: Энэтхэгийн гадаад болого баруун тийшээ тэлэх, өөрөөр хэлбэл Булангийн орнууд, Баруун Ази, Хойд Африкийн орнуудтай харилцаагаа хөгжүүлэхэд чиглэж байна. Онцлог нь эдгээр орнуудтай харилцахдаа үзэл суртал, шашны ялгааг үл харгалзан, байгалийн баялаг тухайлбал, газрын тос, хий, усны асар их нөөцийг сонирхож байгаагаар илэрхийлэгдэж байна.⁵ Мөн эдгээр орнуудаар дамжуулан Европ руу гарах усан замын тээвэр хийх, аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой гэж үзэж байна. Одоогийн байдлаар энэ бүс нутагт Энэтхэгийн худалдаа, хөрөнгө оруулалт ихээхэн хийгдэж, энэтхэгүүд ажил хөдөлмөр эрхлэхээр энэ бүс нутаг руу гарч байна. Энэтхэг мэдээллийн технологи, био технологи, эмийн салбарт түлхүү хамтын ажиллагааг хөгжүүлж байна. 2006 онд Оман, Саудын Араб, Кувэйттэй хамтын ажиллагааны гэрээ байгуулсан байна. Иракийн сэргээн байгуулалтанд идэвхтэй тусламж үзүүлж байна. Ирантай газрын тос, хийн салбарт 2005 оноос идэвхтэй хамтарч ажиллаж байна.

Энэтхэг Палестинтай уламжлалт сайн харилцаатай. 1996 онд Палестины Газын районд Энэтхэг Төлөөлөгчийн газраа нээсэн, Палестины Элчин сайдын яамыг нийслэлдээ - Нью Делид ажиллуулж байгаа нь анхны арабын бус орон. Мөн Израйлтай өргөн салбарт хамтын ажиллагаа хөгжүүлж байна. 2006 онд 15 жилийн ой тохиосон байна.

Хойд Африкийн орнуудаас Йордан, Сири, Ливитэй харилцаагаа хөгжүүлж байгаагаас гадна бүс нутгийн олон улсын байгууллага болох Арабын орнуудын лига, Булангийн орнуудын **хамтын ажиллагааны Зөвлөлтэй** харилцаа хамтын ажиллагаатай ажиллаж байна. Өнөөдөр Хойд

³ U.R.Ghai. *Foreign Policy of India*. New Academic Publishing Co.India. 2009. 488-490 дэхь тал

⁴ V.N. Khana. *India's Nuclear Doctrine*. New Delhi, 2000, 99-100 дэхь тал

⁵ Taran Biswal. *Ed. International Relations*, Macmillan Publishers India Ltd, 2009, 130 дэхь тал

Африкийн болон Арабын орнуудын бослого, хөдөлгөөнийг зохицуулахад Энэтхэг өөрийн гэсэн ашиг сонирхлоос хандаж байгаа нь аливаа олон улсын халуун цэгт идэвхтэй байр сууриа илэрхийлдэг болоод байгааг гэрчилж байна.

Дөрөвдүгээрт: Бидний анхаарлыг татах бүс нутаг бол Энэтхэг, Төв Азийн орнуудын харилцаа юм. Энэтхэг Төв Азийн шинээр тусгаар тогтносон орнуудтай харилцаагаа өргөтгөх асар их сонирхолтой байгаа. Үүний нэг илрэл Энэтхэг ШХАБ-ын ажиглагч орон бөгөөд 2010 онд Энэтхэг ШХАБ-ын гишүүн болох хүсэлтээ илэрхийлсэн явдал юм. Энэтхэгийн хэвлэлийн мэдээлснээр энэ байгууллагад Энэтхэгийг гишүүнээр элсүүлэхэд Хятад төдийлэн нааштай хандаагүй, харин Орос Энэтхэгийг гишүүнээр элсүүлэх явдлыг дэмжсэн явдал юм. Монгол улс ШХАБ-ын ажиглагч орны хувьд Энэтхэг-ШХАБ-ын цаашдын харилцаа бидний анхаарлыг зүй ёсоор татах ёстой.

Тавдугаарт: Энэтхэгийн гадаад бодлогод гарсан нэг шинэ чиглэл бол 1991 онд зарласан “Look East policy” буюу “Дорно руу чиглэсэн бодлого” юм. “Дорно руу чиглэсэн бодлогод” Зүүн Өмнөт Ази, Өмнөт Солонгос, Япон Австрали, Хятад зэрэг орон багтаж байна. Энэтхэг бүс нутгийн хэмжээнд юуны өмнө Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг SAARC –г 1985 онд байгуулуулж, улмаар АСЕАН-ы орнуудтай хамтарч ажиллах идэвхтэй бодлого явуулж байна. АСЕАН-ы орнууд ч АСЕАН +1,2,3 гэх зарчмыг хэрэгжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлыг сахин хамгаалахад Энэтхэгийг чухал хүчин зүйл гэж үзэж байна. 1992 онд АСЕАН-ы Секторын яриа хэлэлцээний түнш байсан бол 1995 онд түүний “бүтэн” яриа хэлэлцээний түнш болсон байна. АНДБН-ийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны Зөвлөл, АСЕАН-ы Бүс нутгийн Форум /1996 / Энэтхэгт ихээхэн ач холбогдол өгч байна. Энэтхэг, АСЕАН-ы дээд хэмжээний уулзалт тогтмолжиж байна. АСЕАН Энэтхэгийн чөлөөт худалдааны бүс болохыг зорьж байна. АСЕАН, Энэтхэгийн эдийн засгийн хамтын ажиллагаа эрчимжиж 1990 онд худалдаа 2,4 тэрбум US\$ байсан бол 2005 онд 23 тэрбум US\$ болтлоо өссөн байна. Энэтхэг АСЕАНЫ гишүүн орнуудтай тус тусд нь чөлөөт худалдааны Гэрээ байгуулан ажиллаж байна. Тухайлбал Сингапур, Тайланд, Малайз, Индонезийг дурьдаж болно.

Монгол улс ч АСЕАН+3 зарчим үйлчлэхэд АСЕАН+4 зарчмыг баримтлах нь гарцаагүй. Энэ нөхцөл байдалд бид бас Энэтхэгийн дэмжлэгийг авах, Энэтхэгтэй хамтарч ажиллах хэрэгтэй.

Япон улсын хувьд хоёр орон аюулгүй байдал, хамтын ажиллагааны хамтарсан тунхаг гаргаснаас гадна стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлж байна. Ялангуяа далай тэнгисийн аюулгүй байдлыг сахин хамгаалахад хоёр тал хамтарч ажиллахыг эрхэмлэж байна.

Өмнөд Солонгостой эдийн засгийн иж бүрэн түншлэлийн харилцаатай байна. 2014 он гэхэд худалдааг хоёр дахин нэмэгдүүлж 30 тэрбум долларт хүргэхээр зорьж ажиллаж байна. Ялангуяа мэдээллийн технологийн салбарт хамтран ажиллахыг чухалчилж байна.

Авсрالي, Энэтхэгийн харилцаа АНДБН-т энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, эдийн засгийн харилцааг хөгжүүлэхэд /худалдаа 8 тэрбум долларт хүрээд байна / чиглэгдэж байна. Авсрالي нь Энэтхэгийг АСЕАН-ы бүс нутгийн форумд элсэн ороход ихээхэн дэмжлэг үзүүлсэн. Авсрالي, Энэтхэгийн хооронд далайн замыг хөгжүүлэх, АНД-ийн аюулгүй байдлаар хамтарч ажиллахыг чухалчилж байгаа юм байна.

Япон, Өмнөд Солонгос, Авсрالي, Энэтхэгийн хувьд нэгдсэн нэг үнэлэмжтэй орнууд, өөрөөр хэлбэл ардчилсан орнууд гэдгээр хамтарч ажиллах хэмжүүрийг тавиад байна. Монгол улс ч энэ хэмжүүрт тэнцэж орох нь гарцаагүй. Мөн АНДБН-ын орнууд бүс нутагт аюулгүй байдлын

баланс барихад Энэтхэгт ихээхэн ач холбогдол өгч байна.

Зургаадугаарт: Энэтхэг их гүрнүүдийн харилцааг тоймлон дурьдая. Энэтхэг Оростой харилцах харилцаанд чухал ач холбогдол өгдөг. ОХУ ч Энэтхэгийг уламжлалт найрамдалт харилцаатай орон гэж үздэг. ЗХУ задарч ОХУ бүрэлдэн тогтсоноос хойш “шинээр тусгаар тогтносон 15 улстай болон ОХУ-тай шинэ зарчмаар харилцах хэцүүхэн зорилт тулгарсны дотор хамгийн чухал нь ОХУ-тай харилцах харилцаа байсан” гэж үзэж, 1993 онд Энэтхэг, ОХУ-ын Найрамдал, хамтын ажиллагааны гэрээ байгуулсан нь ОХУ, Энэтхэгийн шинэ харилцааны эгч зүйн үндэс болсон байна. ОХУ-тай сансрын технологи, цэрэг, батлан хамгаалах, аюулгүй байдлын, салбарт, мөн худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тал дээр хамтарч ажиллаж байна. 2007 онд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины Энэтхэгт хийсэн айлчлалын үеэр сансрын технологи, МИГ 35 байлдааны онгоц нийлүүлэх, цөмийн реактор, уран, хий, газрын тосны салбарт Энэтхэгтэй хамтарч ажиллах болсон байна. Энэтхэг улс болон ОХУ-ын хооронд бүс нутгийн болон дэлхийн хэмжээний аливаа асуудлаар улс төр, эдийн засгийн аль ч төвшинд хамтран ажиллах олон гэрээ, хэлэлцээрүүд хийгдээд байна. Энэтхэг, ОХУ-ын харилцаа стратегийн түншлэлийн хүрээнд явагдаж байна.

Энэтхэг, АНУ-ын тухайд ярихад хоёр улс олон жилийн турш бие биендээ шүүмжлэлтэй хандаж ирсэн. АНУ-ын зүгээс ЭҮНХ-д шүүмжлэлтэй хандаж, Пакистаныг дэмжих бодлого баримталж байсан. АНУ Энэтхэгийг “социалист лагерийн орнуудын хагарлын үед” ашиглахыг оролдож байсан. Тухайлбал 1962 оны Энэтхэг, Хятадын хилийн дайнд АНУ Энэтхэгийг дэмжиж байсан.

Гэвч 1971 онд Зөвлөлт- АНУ-ын, Зөвлөлт-Хятадын, Энэтхэг-Пакистаны харилцаа хурцдаж эхлэхэд Энэтхэг-АНУ-ын харилцаа дээд цэгтээ хүртэл муудсан. Энэ үед АНУ социалист лагерийг задлах зорилгоор Хятадтай харилцаагаа сайжруулахад Энэтхэг зөрүүлээд ЗХУ-тай Найрамдлын гэрээ байгуулж, АНУ-Хятадын Өмнөд Азид нөлөөлөх хүчин зүйлийн эсрэг холбоо тогтоож байсан.

Хоёр орны харилцаа 80-аад оны эхэн үед Индира Ганди, Рональд Рейган нарын үед дулаарах шинжтэй болж ирсэн. Үүнд Зөвлөлтийн цэрэг Афганистанд орох болсон явдал ихээхэн нөлөөлсөн. 1982 онд АНУ Энэтхэгийн Тарапорийн цөмийн энергийн станцыг түлш болон тоног төхөөрөмжөөр хангаж эхэлсэн, 1984 оноос Энэтхэгт технологи шилжүүлж эхэлсэн. 1985, 1987 онд Энэтхэгийн Ерөнхий сайд Ражив Ганди Вашингтонд албан ёсны айлчлал хийж, үр дүнд нь Энэтхэг цэргийн нисэх хүчний программ, F-5 байлдааны онгоц зэрэг техник, технологи авах болсон.

1990 оноос Энэтхэг эдийн засгийн шинэчлэл хийж, зах зээлийг лебиралчлах болсноор АНУ 1,8 тэрбум \$ Олон улсын валютийн сангаас зээл олгоход тусалсан. 1989 онд Зөвлөлт Афганистанаас цэргээ гаргах болсон нь АНУ-ын Пакистаны бодлогыг “зөөллөсөн” Энэтхэг АНУ-тай харилцах нөхцлийг сайжруулж өгсөн.

1994 оны 5 сард Энэтхэгийн Ерөнхий сайд Рао АНУ-д айлчилж, 6 гэрээнд гарын үсэг зурсан, хэдийгээр хоёр орны хооронд санал зөрүүтэй олон асуудал байсан ч харилцааны сувгийг нээж өгсөн гэж үздэг юм байна.

2000 онд АНУ-ын Ерөнхийлөгч Клинтон Энэтхэгт айлчилж, 2005, 2006 онуудад Ерөнхийлөгч Буш Энэтхэгтэй өндөр технологийн болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах салбарт

хамтарч ажиллах болсон нь АНУ-ын зүгээс Энэтхэгтэй “эн тэнцүү” түвшинд хамтрах болсныг гэрчлэх болсон юм.

Энэтхэг, АНУ-ын харилцаа сайжрахад нөлөөлсөн зүйлүүд нь олон улсын терроризм, цөмийн зэвсгийн болон үй олноор устгах зэвсгийг хязгаарлах асуудал тулгарч ирсэн, эрчим хүчний болон байгалийн баялгийн салбарын хэрэгцээ ихдэх болсон, Хятадын эдийн засгийн өсөлт, ардчиллыг хөхүүлэн дэмжүүлэхэд хамтран ажиллах шаардлага гарч ирсэнтэй холбоотой юм. Орчин үед Энэтхэг, АНУ-ын харилцаа стратегийн түншлэл рүү чиглэж байна.

Энэтхэг-Хятадын харилцааны тухайд.

Орчин үеийн Энэтхэг-Хятадын харилцаа товчхондоо хамтарч ажиллах, өрсөлдөх, сөргөлдөх аль алинаар нь тодорхойлогдож байна.

Энэтхэг улс өөрийгөө Азийн ардчилсан хамгийн том орон гэж үздэг бөгөөд Хятадын коммунист систем, хүний эрх болон ардчиллын бусад хэм хэмжээ зөрчигдөж байгаад шүүмжлэлтэй ханддаг юм байна.

Энэтхэг-Хятадын хооронд байдаг нилээд төвөгтэй асуудал бол Төвд-Далай ламын асуудал юм. 1954 оны 4 сард Энэтхэг, Хятад хоёр Төвдийн талаар 8 жилийн хугацаатай гэрээ байгуулсан байдаг. Тэргээрээндээ Панчшилийн зарчмыг баримтална гэж тусгасан нь одоог болтол энэ асуудлыг шийдвэрлэхэд бэрхшээл учруулдаг юм байна. Далай лам 1959 онд 120 мянган төвдүүдтэй Энэтхэгт дүрвэж очсон нь өнөөг хүртэл Өрнийхний анхаарлын төвд байсаар байна. **Энэтхэг улс 2003 он хүртэл Төвдийн эрх чөлөөний төлөө байгаагаа Хятадын талд мэдэгдсээр байсан бол 2003 онд Энэтхэг Төвдийг Хятадын хэсэг гэдгийг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн. 2004 онд Хятад Сиккимийг Энэтхэгийн хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрсөн.** Иймээс Далай Ламыг өнгөрсний дараа Энэтхэг дэх төвдүүд болон Хятад дахь Төвдийн асуудал хэрхэх тал дээр олон орон анхаарлаа хандуулж байна.

Энэтхэг-Хятадын хилийн маргаан өнөөдрийг хүртэл үргэлжилсээр байна. Хилийн маргаанаас болж хоёр улс 1962 онд дайтахад хүрч байсан. 1996 онд Хятадын дарга Зян Зэминь Энэтхэгт айлчлахад хилийн асуудлаар итгэлцлийг бэхжүүлж, хилийн бүс орчмын цэргийн тоог цөөрүүлэх, зэвсгийн тоог хязгаарлах хэд хэдэн баримт бичигт гарын үсэг зурсан.

1988 онд Энэтхэгийн Ерөнхий сайд Ражив Ганди Хятадад айлчилсан нь 1955 онд тухайн үеийн Ерөнхий сайд Жавхарлал Неру Хятадад айлчилснаас даруй 34 жилийн дараа айлчилсан айлчлал болсон. Энэ айлчлалын үр дүнд Энэтхэг-Хятадын харилцаа шинэ шатанд гарч хөгжих эрх зүйн үндэс бий болсон гэж үздэг юм байна. Хоёр улсын хооронд шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагаа, иргэний агаарын тээврийн шууд нислэг хийлгэх, соёлын харилцааг хөгжүүлэх тухай гэрээ хийгдсэн байна.

1994 онд Энэтхэг, Хятад хилийн гэрээнд гарын үсэг зурсан. Хилийн худалдаа хөгжүүлэх, байгаль орчинг хамгаалах, радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн салбарт хамтран ажиллах хэд хэдэн гэрээ байгуулсан байна.

Гэвч 1998 оны 5 сард Энэтхэг цөмийн туршилт хийсэн үеэс хоёр орны харилцаа ухралтын байдалд орсон. Энэтхэгийн Батлан хамгаалахын сайд Жорж Фернандас Хятад Энэтхэгт аюул учруулах номер нэг орон гэж тухайн үед мэдэгдсэн байсан.

2003 оны 6 сард Энэтхэгийн Ерөнхий Сайд Важпай Вэнь Зябаогийн урилгаар Бээжинд айлчилж хоёр орны хооронд “удаан хугацааны үр бүтээлч хамтарсан түншлэлийн харилцаа”

тогтоох Тунхаг бичиг гаргасан. 2005 онд Хятадын Ерөнхий сайд Вэнь Зябао Бээжинд албан ёсны айлчлал хийх үед “Энэтхэг, Хятадын энхтайван, цэцэглэлтийн төлөөх стратегийн хамтарсан түншлэл”-ийн харилцаа тогтоох Тунхаг бичигт гарын үсэг зэрсэн байна.

Энэтхэг, Хятад хоёр мөн огторгуй болон агаарын зайн тусгалтай пуужингаар өрсөлдөж байна. Гэхдээ Азийн хоёр том гүрэн бүс нутгийн болон олон талт хамтын ажиллагаанд олон асуудлаар ижил төстэй байр суурьтай байна.

Энэтхэгтэй хамтарч ажиллах Монгол улсын байр суурийг товчхон тодорхойлбол:

Нэг. Монгол улсын хувьд Энэтхэгтэй хамтарч түүх, шашин, философи, соёлын улбаагаа сэргээн хөгжүүлэх. Энэ нь зөвхөн лам хийдийн хүрээнд биш шинжлэх ухаан, сургалтын хүрээнд хамтарч ажиллахад анхаарах. Энэтхэгийн Ерөнхийлөгч айлчлалынхаа үеэр “манай хоёр орныг өнө эртнээс холбож ирсэн соёлын болон шашны хэлхээ холбоо эдгээр салбарууд дахь харилцааны уламжлалыг бататган бэхжүүлэх хэрэгтэй байна”⁷ гэсэнтэй бүрэн санал нийлж байна.

Хоёр. Ардын дипломатыг хөгжүүлэх. Энэтхэгийн уламжлалт Иога, бясалгал сурах хүсэлтэй монголчууд, Богд, Далай лам болон Бурхны оронд очиж мөргөл үйлдэх хүсэлтэй иргэдийг чөлөөтэй явуулж, ард иргэдийн харилцааг хөгжүүлэх.

Монгол-Энэтхэгийн оюун санааны дипломатыг хөгжүүлэхэд тодорхой төсөл хэрэгжүүлэх.

Гурав. Энэтхэгтэй хамтарч гадаад харилцаа, хууль, банк санхүү, мэдээллийн технологи, англи хэлний салбарт сургалт судалгааны хүрээнд хамтарч ажиллах явдлыг эрчимжүүлэх. Саяын айлчлалаар мэдээллийн технологи, аутсорсингийн салбарт сургууль байгуулах, Энэтхэгийн засгийн газрын тэтгэлгээр Энэтхэгт суралцах монгол оюутны тоог 50 хүртэл нэмэгдүүлэх, техник, эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрт хамрагдагсдын тоог 150-д хүргэхээр шийдвэрлэсэн байна.

Дөрөв. Энэтхэгтэй уул уурхайн салбарт хамтарч ажиллах. Эрдэс баялаг, уул уурхай, түүний дотор цөмийн эрчим хүч, уран, гангийн салбарт боловсруулах үйлдвэр байгуулах, дэд бүтцийн хөгжилд хөрөнгө оруулалт хийхэд хамтарч ажиллах. Чингэхдээ аль аль тал нь олон улсын хууль эрх зүйн орчинг бүрдүүлж чанд сахиж ажиллах

Тав. Өнөөгийн Энэтхэг, Монголын харилцаанд шинээр бий болсон нийтлэг үнэлэмж бол ардчилал. Энэтхэг орон Азийн хамгийн том ардчилсан орон бол Монгол орон социализмаас ардчилал руу амжилттай шилжсэн Азийн хамгийн залуухан ардчилсан орон гэдэг нийтлэг үнэлэмжээрээ бид нэгдэж байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд Монгол, Энэтхэг хоёр улс тусгаар тогтносон үеэсээ бие биенийхээ түүх, соёл, шашинд хэзээ ямагт хүндэтгэлтэй хандаж, хүнд хэцүү цагт олон улсын тавцанд бие биенээ дэмжиж ирсэн сайхан уламжлалтай. Эдүгээ хоёр орны харилцаа сэргэж, цаг үеийн хөгжлийн шаардлагын дагуу эдийн засаг, нийгмийн бүхий л салбарыг хамран хөгжих өргөн боломж нээгдэж байна. Энэ боломжийг бүрдүүлэх хамгийн гол нөхцөл бол гадаад бодлогын нийтлэг эрх ашиг байдаг. Энэтхэгийн гадаад бодлогын онцлог, шинэчлэлийг харьцуулан судлахад манай хоёр орон хоёр талын болон бүс нутаг, олон улсын тавцанд бие биенээ дэмжин идэвхтэй хамтран ажиллах бүхий л бололцоо боломж бүрдсэн байна гэдгийг цохон тэмдэглэе.

⁷ Өнөөдөр сонин. 2011.07.29. № 169